



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 05 сарын 25 өдөр

Дугаар А/245

Ховд

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.4 "в", Авто замын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.4, Зам тээврийн хөгжлийн сайдын 2018 оны 3 дугаар сарын 14-ний өдрийн 49 дүгээр тушаалаар батлагдсан журмыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. ХОАОНӨГ/202101074 гэрээний дугаартай Ховд аймгийн Эрдэнэбүрэн сумын Хонгио багийн Нарийн усны зам засварын ажлыг байнгын ашиглалтанд оруулах комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Комиссын дарга:	Б.Баярсүх	- Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга
Гишүүд:	С.Батдорж	- Аймгийн Засаг даргын Тамгын газрын Архивын тасгийн дарга
	Б.Ганзориг	- Мэргэжлийн хяналтын газрын авто замын хяналтын улсын байцаагч
	У.Цэрэнтогтох	- Эрдэнэбүрэн сумын Засаг дарга
	Д.Батболд	- Эрдэнэбүрэн сумын Хонгио багийн Засаг дарга
	Б.Даваацэрэн	- Эрдэнэбүрэн сумын Байгаль орчны хяналтын улсын байцаагч
Нарийн бичгийн дарга:	Д.Эрдэнэбат	- Аймгийн Засаг даргын дэргэдэх Зөвлөх багийн ахлагч

2. ХОАОНӨГ/202101074 гэрээний дугаартай Ховд аймгийн Эрдэнэбүрэн сумын Хонгио багийн Нарийн усны зам засварын ажлыг ажлын даалгавар, зураг төсвийн дагуу, хуулийн хүрээнд байнгын ашиглалтанд авч ажиллахыг ажлын хэсгийн ахлагч /Б.Баярсүх/-д даалгасугай.

3. Дээрх ажлын захиалагчийн хяналтын зардлаас комиссын гишүүдийн шатахуун, унаа, хоол, томилолтын зардлыг санхүүжүүлэхийг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга /Б.Баярсүх/, Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/ нарт зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ